

“НАРИЙН СУХАЙТ – БАЯНХӨНДИЙ 242 км 110 кВ ЦДАШ, 2х16 МВА ДЭД СТАНЦ
ТӨСӨЛ”-ИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

/Аж ахуй нэгжийн регистрийн дугаар - 2090007/

БОЛОВСРУУЛСАН:

НАРИЙН СУХАЙТ – БАЯНХӨНДИЙ 242 км 110 кВ
ЦДАШ, 2х16 МВА ДЭД СТАНЦ ТӨСЛИЙН УДИРДАГЧ

Ө.ЦОГТБАЯР

Улаанбаатар хот

2025 он

АГУУЛГА

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

- 1.1. Төслийн нэр
- 1.2. Төсөл хэрэгжүүлэгч
- 1.3. Төсөл хэрэгжүүлэх нутаг дэвсгэр, талбайн байршил
- 1.4. Төслийн хүчин чадал, танилцуулга
- 1.5. Барилга угсралтын үеийн түр байгууламж

ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

- 2.1. Байгаль орчны товч танилцуулга
- 2.2. Физик газарзүйн онцлог
- 2.3. Геоморфологи
- 2.4. Цаг уур, уур амьсгалын үндсэн нөхцөл
- 2.5. Хөрсөн бүрхэвч
- 2.6. Гадаргын болон газрын доорх усны төлөв байдал
- 2.7. Гидрогеологийн нөхцөл
- 2.8. Ургамалжилтын төлөв байдал
- 2.9. Амьтны аймгийн төлөв байдал
 - 2.9.1. Хөхтөн амьтад
 - 2.9.2. Мөлхөгчид
 - 2.9.3. Шувууд
- 2.10. Нийгэм эдийн засгийн төлөв байдал
 - 2.10.1 Баянхонгор аймаг, Шинэжинст сумын нийгэм, эдийн засаг
 - 2.10.2 Өмнөговь аймаг, Гурвантэс сумын нийгэм, эдийн засаг

ГУРАВ. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

- 3.1. Байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим
- 3.2. Төслийн болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим

ДӨРӨВ. 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

- 4.1. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө
 - 4.1.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээний төлөвлөгөө
 - 4.1.2. Нөхөн сэргээлт, ногоон байгууламжийн төлөвлөгөө
 - 4.1.3. Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө
 - 4.1.4. Нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговор олгох төлөвлөгөө
 - 4.1.5. Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө
 - 4.1.6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө
 - 4.1.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө
- 4.2. Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр
 - 4.2.1. Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр
 - 4.2.2. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь
 - 4.2.2.1 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг тайлагнах хуваарь

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн нэр

“Нарийн Сухайт – Баянхөндий 242 км 110 кВ ЦДАШ, 2х16 МВА дэд станц төсөл”

1.2. Төсөл хэрэгжүүлэгч


Эрчим хүч худалдан авагч: “Эрдэнэ Монгол” ХХК

Эрчим хүч нийлүүлэгч: “М Си Эс Интернэйшнл” ХХК

1.3. Төсөл хэрэгжүүлэх нутаг дэвсгэр, талбайн байршил


ЦДАШ-ын төлөвлөж буй трасс нь Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутгаар 74.5 км, Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутгаар 167.5 км бөгөөд үүнээс Тост, тосон бумбын нурууны байгалийн нөөц газар нутгаар 120.5 км, Говь гурвансайханы байгалийн цогцолборт газар нутгаар 22.17 км тус тус дайран өнгөрнө.

Зураг 1. Төслийн байршилын зураг



ЦДАШ-ын трассын хэмжээнд уулсын ам, хөндий дагуух сайр болон уулсын бэлээс дооших хэвгйдүү талархаг газрыг самнан буусан янз бүрийн гүн, өргөн нарийнтай сайруудын голдирол дагуу тавигдана. Трасс нь Говь Алтайн салбар уулсын зүүн өмнөд зах болох Тост, Тосон бумбын нурууны өвөр хэсэг, Бүлээний сайр, Тостын сайр, Цагаан толгойн сайр, Хөх эргийн сайраар дамжин Тост, тосон бумбын нурууны байгалийн нөөц газрын баруун өмнө талаар Тост уул, Дэлийн хярын дундуур гарч Тосон бумбын нурууны өмнө талаар дамжин Говь Гурвансайхан байгалийн цогцолборт газрын зүүн өмнө захаар дайрч Дэлийн тал, Шаригийн тал, Ингэн хөөврийн говь хүртэл үргэлжлэн Гангын хар толгойн сайр, Гангийн усны сайр зэрэг урт сайрууд, энэ сайруудаас баруун тийш чиглэсэн Ногоон цавын хоолой, Хар боомын сайр зэргээр дамнан Гурван улаан хоолойн сайрыг хөндлөн гарч Баянхөндийн говьд хүрнэ.

Зураг 2. ЦДАШ-ын трасс зураг



Хүснэгт 1. Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутгаар дайран өнгөрөх 167.5 км 110 кВ ЦДАШ-ын эргэлтийн цэгийн координат

Байршил	Эргэлтийн цэг	X,m WGS84 UTM system	Y,m WGS84 UTM system
Өмнөговь аймгийн Гурвантэс сум Урт=167,5 км	УГ-0	683204.715	4757691.449
	УГ-1	683104.475	4757662.035
	УГ-2	681612.053	4757070.134
	УГ-3	681354.554	4757015.995
	УГ-4	681281.361	4757024.654
	УГ-5	671820.918	4756405.997
	УГ-6	669583.000	4757976.000
	УГ-7	669513.659	4759222.061
	УГ-8	669792.445	4762279.39
	УГ-9	669446.248	4762591.58
	УГ-10	669328.07	4764229.375
	УГ-11	665024.759	4766485.275
	УГ-12	621099.713	4771417.193
	УГ-13	617590.758	4776266.266
	УГ-14	615012.161	4779345.606
	УГ-15	591532.341	4784326.134
	УГ-16	583870.058	4785215.984
	УГ-17	570967.133	4796121.356

Хүснэгт 2. Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутгаар дайран өнгөрөх 74.5 км 110 кВ ЦДАШ-ын эргэлтийн цэгийн координат

Байршил	Эргэлтийн цэг	X,m WGS84 UTM system	Y,m WGS84 UTM system
Баянхонгор аймгийн Шинэжинст сум Урт=74,5 км	УГ-18	533481.301	4820060.2
	УГ-19	501323.959	4831656.891
	УГ-20	495617.002	4839176.882
	УГ-21	488118.81	4846135.769
	УГ-22	486927.234	4849107.745
	УГ-23	486944.343	4850147.547
	УГ-24	486403.325	4856104.257

	УГ-25	486551.602	4856996.907
	УГ-26	485337.257	4858682.295
	УГ-27	484464.548	4860294.903

1.4. Төслийн хүчин чадал, танилцуулга

Төслийн гүйцэтгэх ажлын хүрээ нь Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Баянхөндий уурхайгаас Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Нарийн Сухайт дэд станц хүртэл 242 км зайд 110 кВ ЦДАШ-ын угсралт болон Баянхөндий уурхайн төслийн талбай дэд станцаас ажилчдын амрах байр хүртэл 11 кВ 7.7 км ЦДАШ-ын угсралтын ажлуудыг хийж гүйцэтгэх бөгөөд ЦДАШ-ын хамгаалалтын зурвас нь Эрчим хүчний тухай хууль, Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрмийн дагуу захын утаснаас хоёр тийш 20 метр зайд байна. Төслийн хэмжээнд нийт 77 ширхэг анкер тулгуур бүрд 4 ширхэг бетон суурийг газарт ухаж суурилуулна. Нийт 1466 ширхэг завсрын тулгуур суурилуулах ба тулгуур тус бүрд 1 ширхэг бетон чагт ухаж суурилуулна.

Төслийн суурилагдсан хүчин чадал нь 10.8 МВт нэг хэлхээт 242 км ЦДАШ, 2750 кВА х 2 дизель генератор, нийт 1466 ширхэг завсрын бетон тулгуур, тулгуур хоорондын зай ~150 м, нийт 77 ширхэг анкер тулгууртай байхаар төлөвлөсөн.

Хүснэгт 3. Төслийн товч тодорхойлолт


№	Үндсэн үзүүлэлтүүд	Тайлбар
1	Төслийн нэр	Нарийн Сухайт – Баянхөндий 242 км 110 кВ ЦДАШ, 2х16 МВА дэд станц төсөл
2	Төсөл хэрэгжүүлэгч байгууллага	М Си Эс интернэйшнл ХХК
3	Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимп, 19а, Шангри-ла оффис, 7-р давхар, 704 тоот Утас: (976)-77226262, 77226464, 88882488, 80006672
4	Төсөл хэрэгжүүлэгчийн хүчинтэй хууль эрх зүйн баримт бичгүүдийн жагсаалт	М Си Эс Интернэйшнл ХХК Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ: - Улсын бүртгэлийн дугаар: 9011035035 - Улсын регистрийн дугаар: 2090007 Эрчим хүчний байгууламж барих, ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл: - Дугаар: 2024/Ц-49 Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ: - Гүйцэтгэгч: Грийн Ассесмент ХХК

1.5. Барилга угсралтын үеийн түр байгууламж

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт байрлах Баянхөндий уурхайн кемпийн түр байгууламжид захиалагч болон гүйцэтгэгчийн оффис, ажилчдын кемп /гэр/, материал буулгах, түр хадгалах талбай, засвар техник үйлчилгээний талбай, автомашины зогсоол, харуул хамгаалалтын байр, био бие засах газар, хогийн цэг, дизель генератор, гадна гэрэлтүүлэг зэргээс бүрдэнэ.

Төслийн хүрээнд Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт дундын кемпийн түр байгууламж байгуулна. Дундын кемпийн түр байгууламжид захиалагч болон гүйцэтгэгчийн оффис, ажилчдын кемп /гэр/, материал буулгах, түр хадгалах талбай, автомашины зогсоол, харуул хамгаалалтын байр, бие засах газар, хогийн цэг, дизель генератор, гадна гэрэлтүүлэг гэсэн хэсгүүдээс бүрдэнэ.

Зураг 3. Түр байгууламжийн төлөвлөлтийн зураг




ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1. Байгаль орчны товч танилцуулга

ЦДАШ-ын трассын хэмжээнд уулсын ам хөндий дагуух сайр болон уулсын бэлээс дооших хэвгйдүү талархаг газрыг самнан буусан янз бүрийн гүн, өргөн нарийнтай сайруудын голдирол дагуу тавигдана. Трасс нь Говь-Алтайн салбар уулсын зүүн өмнөд зах болох Тост, тосон бумбын нурууны өвөр хэсэг, Бүлээний сайр, Тостын сайр, Цагаан толгойн сайр, Хөх эргийн сайраар дамжин Тост, тосон бумбын нурууны байгалийн нөөц газрын баруун өмнөд талаар Тост уулс, Дэлийн хярын дундуур гарч Тосон бумбын нурууны өмнө талаар дамжин Говь гурвансайхан байгалийн цогцолборт газрын зүүн өмнө захаар дайрч Дэлийн тал, Шаригын тал, Иргэн хөөврийн говь хүртэл үргэлжлэн Гангын хар толгойн сайр, Гангын усны сайр зэрэг урт сайрууд, энэ сайруудаас баруун тийш чиглэсэн Ногоон цавын хоолой, Хар боомын сайр зэргээр дамнан Гурван улаан хоолойн сайрыг хөндлөн гарч Баянхөндийн говьд хүрнэ.

Зураг 4. Төслийн байршлийн зураг /Засаг захиргааны байршлаар/




2.2. Физик газарзүйн онцлог

Баянхөндийгөөс урагш трассын дагуу түүний ойролцоо байгаа уулсыг дурдвал, Холбоотолгой (1224 м), Сүүж толгой (1257 м), Хар овоо толгой (1422 м), Чавхат ар уул (1151 м), Алаг овоот толгой (1021 м), Онгон улаан уул (1235 м), бутархай толгой (914 м), Иргэн хөөвөр толгой (791 м), Хүрэн овоот уул (1481 м) зэргийг нэрлэж болох ба эдгээр уулс нь гол төлөв нам ба дундаж өндөртэй уулсад хамрагдана.

Харин Нарийн Сухайт талаас трассын дагуу түүний ойролцоо байгаа уулсыг дурдвал, Тостын нуруу, Тосон бумбын нуруу үргэлжлэх бөгөөд түүний үргэлжлэл болох Тахилт уул (2018 м), Улаан уул (1942 м), Шарга морьт уул (2517 м), Буурал өндөр уул (2373 м), Бага алаг уул (1679 м), Зүүн таван уул (1843 м), Шариг уул (1672 м), Хүрэн шивээт уул (1481 м), Үүрт толгой (1371 м) зэргийг нэрлэж болох ба эдгээр уулс нь гол төлөв нам ба дундаж өндөртэй уулсад хамрагдана.

Трассын дагуу хамгийн нам цэг далайн түвшнээс дээш 680 м орчим өндөр өргөгдсөн бөгөөд энэ нь Ногоон цавын хоолойд бий. Дээр дурдсан уулсын харьцах өндөр их биш ба ойролцоох нам цэгээс дээш 200-300 метрээс үл хэтэрнэ. Уулсын харьцах өндөр дунджаар 150 м юм.

Зураг 5. Байгалийн бүс бүслүүрийн зураг



2.3. Геоморфологи


Говь-Алтайн уулт тогтолцооны гарал үүслийн хөгжил нь шинэхэн тектоникийн уул үүсэх хөдөлгөөнтэй холбоотой бөгөөд энэ асуудлаар судлаачдын санал нэлээд хол зөрүүтэй бас маргаантай байдаг боловч ихэнх нь Говь-Алтайн уулт өргөгдлийг плиоцен, плейстоцены заагт болж өнгөрсөн гэдэг ба тогтцын хувьд хагарлуудаар хэсэг бүлэг блокуудад хуваагдаж шилжин хөдлөхийн зэрэгцээгээр янз бүрийн цаг үеүдэд эргэж хөрвөж, атирч, эвдэрч өөрчлөгдсөн нэн ээдрээтэй, нийлмэл бүтэцтэй гэж үздэг.

Говь-Алтайн нуруу, түүний системд багтаж буй өмнөд хэсгийн зэрэгцсэн, цуварсан хэсэг бүлэг уулс, тэдгээрийг өөр хооронд нь заагласан өргөн уудам бэл хөндийг шинээр тавигдах ЦДАШ дамжин өнгөрөхөөр төлөвлөгдсөн.

Тухайн нутгийн геологийн тогтоц, түүний түүхэн хөгжлөөс улбаалан физик газарзүйн өвөрмөц нөхцөлд бүрэлдэн бий болсон орчин үеийн хотгор гүдгэрийг (газрын гадаргыг) гадаад хэлбэр төрхөөр (морфогенетик) нь:

1. Хэрчигдэл ихтэй тектоник эвдрэлийн хэв шинжит хотгор гүдгэр;
2. Суурилаг тал буюу бэлийн хэв шинжит хотгор гүдгэр;
3. Тэгшрэлийн хэв шинжит хотгор гүдгэр;
4. Аоловийн буюу салхин гаралтай хотгор гүдгэр;
5. Элэгдэл хуримтлалын хэв шинжит хотгор гүдгэр гэж ангилав.

Зураг 6. Ландшафтын зураг



2.4. Цаг уур, уур амьсгалын үндсэн нөхцөл

ЦДАШ-ын трасс нь Өмнөговь аймгийн Гурвантэс сум болон Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутгийн засаг захиргаанд харьяалагдах өмнөд Алтайн говь болон Говь-Алтайн уулсын хойд уулархаг бүс нутгийг дайран өнгөрнө. Уур амьсгал, геотехникийн нөхцөлөөр ангилбал төслийн трасс нь говь цөлийн бүсийн говийн дэд бүсэд, хэт хуурай - хүйтэн, хэт хүйтэн бүсэд хамаардаг. Монголын бусад бүс нутгийн адил эх газрын уур амьсгалтай тул урт хуурай зун, хэт хүйтэн өвөлтэй байна. Хуурай бүс нутагт хамаардаг тул маш бага хэмжээний хур тунадас унаж, хавар, намарт уулсын хөндийгөөр хүчтэй салхилдаг.

Энэхүү трасс нь уур амьсгалын IIB, IIIA, IIIB дэд бүсүүдээр дайран өнгөрөх ба эдгээр бүсүүдийн товч тодорхойлолтыг дор дурдав. Үүнд:

Хүснэгт 5. ЦДАШ-ын трассын бүс нутгийн гол шинж чанар

Бүсийн дугаар, нэр	Дэд бүсийн индекс	Бүсийн товч тодорхойлолт	Уур амьсгалын болон хөрсний нөхцөл
II - Хээрийн бүс	Уулын завсар хоорондын тал хээрийн бүс	Уур амьсгалын хуурай - хүйтэн сэрүүвтэр хахир, хуурайдуу сэрүүвтэр хүйтэн бэсрэг уулст хээр, хээр талын	Олон жилийн цэвдэг чулуулаг алаг цоог болон ховор алаг тархсан, улирлын хөлдөлт гэсэлттэй, хүйтний овойлттой болон суумтгай лёсс маягийн хурдас элбэг тархсан, ойт хээртээ цасархаг, цас борооноос намаг хавар ихтэй, бороорхог, аянгалаг, хээр талдаа цас нимгэн,

		хахирлаг дэд бүс	нягтархаг, салхитай, хахир хүйтэн жаварлаг.
III - Говь цөлийн бүс	Говийн дэд бүс	Уур амьсгалын нэн хуурай дулаан, хүйтэн, хүйтэвтэр хахирлаг говийн цөлжүү хээр, заримдаг цөлийн дэд бүс	Олон жилийн цэвдэггүй. Гео уур амьсгалын улирлын хөдлөлтийн гүн харьцангуй их, хүчтэй салхи шороон шуургатай, халуун бүгчим хуурай онцлогтой, газар хөдлөл рихтерийн шаталбараар 6-9 балл.

Хүснэгт 6. Уур амьсгалын бүсүүдийн улирлын үргэлжлэх хугацаа

Бүс	Дэд бүс	Өвөл			Хавар		Зун		Намар
		Эхлэх	Дуусах	Үргэлжлэх хоног	Дуусах	Үргэлжлэх хоног	Дуусах	Үргэлжлэх хоног	Үргэлжлэх хоног
II	II.B	1-9.XI (5.XI)	15-24.III (19.III)	126-143 (134)	6-12.V (9.V)	45-52 (48)	8-19.IX (13.IX)	112-156 (129)	44-54 (49)
III	III.A.B	2-15XI 9.XI	9-24.III (16.III)	126-146 (136)	25.IV-5.V (1.V)	35-55 (45)	25.IX-1.X (28.IX)	145-159 (152)	42-46 (44)

Тайлбар;* Өвлийн дуусах хугацаа хаврын эхлэл, хаврынх, зуны эхлэл, зуных намрын эхлэл, өвлийн эхлэл, намрын дуусах хугацаа болно. Хаалтад үзүүлсэн тоонууд нь арифметикийн дундаж утга

2.5. Хөрсөн бүрхэвч

Талбайн судалгаа ба хөрсний дээж авалт. Судалгааны талбайд хөрсний хээрийн судалгаа буюу дээж авалт болон ажиглалт хэмжилтийг 2024.03.01-03-нд хийж гүйцэтгэсэн. Нийт судалгааны талбайн хэмжээнд хөрсний хэмжилт дээжлэлтийг 10 цэгт шимт хөрсний буюу0-35 см хүртэлх гүнүүдээс дээжлэлт хийж нийт 14 ширхэг дээж авсан. Хөрсний хүнд металлын дээжийг холимог байдлаар авсан. Дээжийг авахдаа “Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд MNS 3298:1990” стандартыг баримталсан. Хөрсний дээжлэлт хийсэнцэгүүдийн талаарх мэдээллийг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 7. Хөрсний дээж авсан цэгийн ерөнхий мэдээлэл

Цэгийн дугаар	Хөрсний төлөв	Дээж авсан газар	X	Y
PLS-1	Ердийн	Трассын төгсгөл орчим	98.80573	43.896314
PLS-2	Ердийн	Трассын 218-р км орчим	98.932756	43.714754
PLS-3	Ердийн	Трассын 196-р км орчим	99.142722	43.602608
PLS-4	Ердийн	Трассын 172-р км орчим	99.428691	43.529663
PLS-5	Ердийн	Трассын 147-р км орчим	99.675208	43.40848
PLS-6	Ердийн	Трассын 119-р км орчим	99.961817	43.263263
PLS-7	Ердийн	Трассын 107-р км орчим	100.143036	43.201338
PLS-8	Ердийн	Трассын 78-р км орчим	100.426004	43.144563
PLS-9	Ердийн	Трассын 46-р км орчим	100.778687	43.056031
PLS-10	Ердийн	Трассын эхлэл орчим	101.24828	42.951595

Төслийн талбайн хөрсөн бүрхэвчийн тархалт, онцлог

Судалгааны талбай нь нийт трассаас хоёр тийш 500 м буюу нийтдээ 1 км өргөн зурвасыг хамрах бөгөөд талбайн хүрээнд аараг толгод бүхий гадарга нь гуу жалгын хэрчигдэл ихтэй нам уулс болон тэдгээрийн хоорондох өргөн нарийн хуурай сайрууд, тэгшивтэр хөндий болон талархаг хотос хонхор гадарга, жижиг дов довцог, шалархуу хотгор хонхор, элсэрхэг дов довцог зэрэг гадаргын олон янзын хэлбэрийг хамарч д.т.д 719-2021 м өндөрт байрлана. Судалгаанд хамрагдсан талбайд Монгол орны хөрсний ангиллаар Бор саарал болон бүс дундын, сайрын хөрсний дэд хэв шинжид багтах чулуурхаг, нимгэн, сайргархаг, элсэрхэг, хужирлаг, гөлтгөнөт төрлийн хөрснүүд дангаараа болон бүрдэл байдлаар тархсан байна.

Эдгээр хөрс нь ерөнхий үржил шимийн түвшин маш бага, шимт үе давхарга нь нимгэн (0-30 см), хэврэг өрмөнцөр, жижиг бөөмөрхөг болон үйрмэг бүтэцтэй, механик нөлөөлөлд тэсвэргүй, байгалийн аясаараа нөхөн сэргэх чадамж маш сул байдаг онцлогтой. Мөн маш их чулуурхаг, том ширхэгтэй элсний агууламж өндөртэй байна. Хөрсний үе давхарга нь ихэвчлэн Q-B-BC-C гэсэн дараалалтай, хөрсний дээд үе давхаргын (0-30 см) ялзмагийн агууламж 0.1-0.33%, элсэрхэг биш хөрсний бүх үе давхарга карбонатжилттай, урвалын орчин 8.1-9.7 буюу дунд зэргээс хүчтэй шүлтлэг, хялбар уусах давсжилт гөлтгөнө бүхий хөрсөнд их буюу 1.4-3.3 dS/m байна. Хөрсний ширхгийн бүрэлдэхүүнд том ширхэгтэй элсэн фракц зонхилсон элсэнцэр болон нарийн элсэн механик бүрэлдэхүүнтэй. Нөлөөлөлд өртөөгүй ердийн хөрсний өнгөн үе давхарга дахь хортой болон био-идэвхт хүнд металлын агууламж стандартын хүлцэх агууламжаас ноцтой хэтэрсэн тохиолдол байхгүй хэвийн түвшинд байна.

2.6. Гадаргын болон газрын доорх усны төлөв байдал

Төсөл хэрэгжих талбай нь Алтайн Өвөр говийн сав газрын усны нөөцөд багтдаг. Усны гадаргаас уурших ууршил 200 см/жил хүртэл байдаг бол ууршиц 80 см/жил-ээс их байна. Энэ нь тус бүс нутаг гадаргын усны болон хөрсний чийг багатай байдгаас уурших усны хэмжээбага, харин уурших боломжит хэмжээ манай орны хувьд хамгийн их байдаг нутаг юм. Жилийн дундаж хур тунадасны хэмжээ 100 мм-ээс бага, үүнээс дулааны улиралд 100 мм буюу түүнээс бага, зөвхөн зарим хэсэгт 100-150 мм, өвлийн улиралд 10 мм-ээс бага хур тунадас тус тус унана.

Зураг 7. ЦДАШ-ын дагуух гадаргын ус



Гол мөрний олон жилийн дундаж урсцын модуль нэн бага буюу 1 с км^2 -аас бага /түр урсгал бүхий гол горхины мужид багтдаг/, олон жилийн дундаж урсцын давхраа 25 м-ээс бага, 1 хувийн хангамж бүхий шар ус, хур борооны үерийн хамгийн их урсацын модуль тус тус $0.1 \text{ м}^3/\text{с}$ -ээс бага /түр урсгал бүхий гол горхины муж/ байна. Бэлчээрийн болон унд ахуйн усны эх үүсвэр нь газрын доорх ус байх ба тус бүс нутагт сульфат зонхилсон эрдэсжилт ихтэй.

2.7. Гидрогеологийн нөхцөл

Гидрогеологийн региональ зүй тогтлын хувьд тус бүс нутаг нь Өмнөд говийн бүсэд хамаарна. Өндөр өргөгдсөн уулсыг гидрогеологийн массив, уулс хоорондын хотгорыг гидрогеологийн бассейн гэж ялгадаг. Энэхүү ЦДАШ-ын трассын чиглэлд геологийн тогтоц буюу газрын доорх ус агуулах геологийн орчны хувьд хоорондоо ялгаатай хэд хэдэн гидрогеологийн массив ¹ болон бассейн ялгагддаг.


Газрын доорх ус агуулах геологийн орчин буюу гидрогеологийн структур нь бүс нутгийн геологийн хөгжлийн түүх, тектоник хөдөлгөөний өрнөл, эдгээрийн дараа хэлбэржин тогтсон орчин үеийн геологийн биетүүдийн хэлбэр зэргээс хамааран өөр өөрийн онцлогтой.

Гидрогеологийн массив нь тодорхой хэмжээгээр ан цавын коллектор бүхий газрын доорх усны агуулж түүний тэжээгдлийн бүс нутаг нь болж байдаг. Гидрогеологийн ай сав нь голчлон нүх сүвний коллектор бүхий газрын доорх усны хуримтлалын болон илэрцийн бүс

¹ Чулуулгаас бүрдэх бөгөөд гадаад хүчний хагарлын бүс дэх ан цавын усыг өөртөө агуулдаг. Идэвхитэй ус солилцооны бүсийн зузаан 100-150 м –ээс илүүгүй байна.

юм. Өөрийн тархалтын талбайн хэмжээгээр хур тунадасны усыг газрын гүнд нэвчүүлэх боловч геологи, геоморфологийн онцлогоос хамаарч газрын доорх усны хуримтлал үүсгэдэг. Манай өмнөд говийн бүсэд ийм тохиолдол ховор. Нарийн Сухайт - Баянхөндий чиглэлийн ЦДАШ-ын трасс дагуу газрын гадаргаас шууд тэжээгдэж газрын доорх усны хуримтлал үүсгэдэг гидрогеологийн ай сав байхгүй байна.

Зураг 8. Газрын доорх усны урсгал



ЦДАШ-ын трассын дагуух гидрогеологийн нөхцөлөөс үзэхэд хэд хэдэн эгнээ цувраа, зэрэгцсэн уулс, аараг толгод болон тэдгээрийн ар өврийн уудам хөндий дагуу гидрогеологийн массив, бассейн ээлжлэн тааралдах бөгөөд гидрогеологийн массив нь илүү эмзэг, гидрогеологийн бассейн нь газрын доорх усны түвшин гүнд байрладаг болон ус агуулагч үе нь ихэвчлэн шаварлаг хурдсаар хучигдан орших тул газрын гадаргад явагдах хүний үйл ажиллагаанд өртөх нь бага байна.

2.8. Ургамалжилтын төлөв байдал

Өмнөговь аймгийн Гурвантэс сумаас Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт байрлах “Эрдэнэ Монгол” ХХК-ийн Баянхөндий алтны уурхай хүртэлх “Цахилгаан дамжуулах агаарын шугам”-ын трассын талбай нь Монгол орны ургамал газарзүйн тойргоор Алашаа говийн /цөлийн/ тойргоор, Алтайн өвөр говийн /цөлийн/ тойргуудад хамаарагддаг. (Өлзийхутаг.Н)

Зураг 9. Монгол орны ургамал-газар зүйн мужлал




2.9. Амьтны аймгийн төлөв байдал

2.9.1 Хөхтөн амьтад

Судалгааны талбай нь Монгол улсын хөхтөн амьтны улаан дансны бүс нутгийн тархалтын бүсчлэлээр Алтайн өвөр говь болон Алашань говь цөлийн бүсэд хамаарна.

Зураг 23. Монгол улсын хөхтөн амьтны улаан дансны Бүс нутгийн тархалтын бүсчлэл (Академич Ш.Цэгмид 1969, В.И. Грубов, 1982)



1-Хөвсгөлийн уулс, 2-Хэнтий нуруу, 3-Хангайн нуруу, 4-Монгол Дагуурын хээр, 5-Их Хянганы уулс, 6-Монгол Алтайн нуруу, 7-Төв халхын хээр, 8-Дорнод Монгол, 9-Их нууруудын хотгор, 10-Олон нуурын хөндий, 11-Умард говь, 12-Дорнод говь, 13-Говь Алтайн нуруу, 14-Зүүнгарын говь цөл, 15-Алтайн өвөр говь цөл, 16-Алашань говь цөл

Хүснэгт 8. Судалгааны талбайд тархсан хөхтөн амьтдын зүйлийн жагсаалт, хамгааллын статус

№	Шинжлэх ухааны нэр	Монгол нэр	Олон улсын үнэлгээ		Бүс нутгийн үнэлгээ
1	<i>Vulpes corsac</i>	Хярс	LC	2014	NT
2	<i>Vulpes vulpes</i>	Шар үнэг	LC	2016	LC
3	<i>Canis lupus</i>	Саарал чоно	LC	2018	NT
4	<i>Lynx lynx</i>	Шилүүс	LC	2015	NT
5	<i>Otocolobus manul</i>	Мануул мий	LC	2020	NT
6	<i>Uncia uncia</i>	Цоохор ирвэс	EN	2017	EN
7	<i>Vormela peregusna</i>	Эрээн хүрнэ	VU	2016	DD
8	<i>Mustela erminea</i>	Цагаан үен	LC	2016	LC
9	<i>Martes foina</i>	Суусар булга	LC	2016	DD
10	<i>Mustela eversmanii</i>	Өмхий хүрэн	LC	2008	LC
11	<i>Ursus arctos gobiensis</i>	Мазаалай баавгай	CR	2016	CR
12	<i>Procapra gutturosa</i>	Цагаан зээр	LC	2008	EN
13	<i>Gazella subgutturosa</i>	Хар сүүлт	VU	2017	VU
14	<i>Capra sibirica</i>	Янгир ямаа	NT	2008	NT
15	<i>Eptesicus serotinus</i>	Хожуу сармаахай	LC	2021	DD
16	<i>Eptesicus gobiensis</i>	Говийн сармаахай	LC	2008	LC
17	<i>Vespertilio murinus</i>	Буурал сармаахай	LC	2016	LC
18	<i>Plecotus austriacus</i>	Том соотон багваахай	LC	2021	DD
19	<i>Hemiechinus auritus</i>	Дэлдэн зараа	LC	2008	LC
20	<i>Mesechinus dauuricus</i>	Дагуур зараа	LC	2008	LC
21	<i>Crocidura sibirica</i>	Малтаахай	LC	2008	DD
22	<i>Lepus tolai</i>	Бор туулай	LC	2018	LC
23	<i>Ochotona dauurica</i>	Дагуур огдой	LC	2016	LC
24	<i>Ochotona alpina</i>	Тагийн огдой	LC	2016	LC
25	<i>Ochotona pallasii</i>	Үхэр огдой	LC	2008	LC
26	<i>Equus hemionus</i>	Хулан адуу	NT	2015	EN
27	<i>Phodopus campbelli</i>	Орог зусаг	LC	2008	LC
28	<i>Allocricetulus curtatus</i>	Цомч шишүүхэй	LC	2014	LC
29	<i>Microtus limnophilus</i>	Зүлгийн оготно	LC	2008	DD
30	<i>Eolagurus przewalskii</i>	Түвд ов	LC	2008	DD
31	<i>Cricetulus migratorius</i>	Бордуу шишүүхэй	LC	2008	DD
32	<i>Phodopus roborovskii</i>	Элсний зусаг	LC	2008	LC
33	<i>Cricetulus longicaudatus</i>	Сүүллэг шишүүхэй	LC	2008	LC
34	<i>Alticola barakshin</i>	Говь алтайн баргачин	LC	2008	DD
35	<i>Euchoreutes naso</i>	Соотон алагдаахай	LC	2008	VU
36	<i>Allactaga balikunica</i>	Өмнөговийн алагдаага	LC	2008	LC
37	<i>Stylodipus andrewsi</i>	Монгол даахай	LC	2008	LC
38	<i>Allactaga bullata</i>	Говийн алагдаага	LC	2008	DD
39	<i>Salpingotus kozlovi</i>	Козловын атигдаахай	LC	2008	DD
40	<i>Dipus sagitta</i>	Элсч савагдаахай	LC	2008	LC
41	<i>Pygeretmus pumilio</i>	Зээл алгадааганцар	LC	2008	LC
42	<i>Allactaga sibirica</i>	Сибир алагдаага	LC	2008	LC
43	<i>Salpingotus crassicauda</i>	Өөхөн сүүлт атигдаахай	LC	2008	DD
44	<i>Cardiocranius paradoxus</i>	Таван хуруут атигдаахай	DD	2008	DD
45	<i>Meriones unguiculatus</i>	Монгол чичүүл	LC	2008	LC

46	<i>Rhombomys opimus</i>	Морин чичүүл	LC	2008	LC
47	<i>Mus musculus</i>	Гэрийн хулгана	LC	2014	LC
48	<i>Meriones meridianus</i>	Шаргал чичүүл	LC	2008	LC
49	<i>Marmota sibirica</i>	Монгол тарвага	EN	2008	EN
50	<i>Spermophilus erythrogenys</i>	Бозлог зурам	LC	2008	LC

2.9.2 Мөлхөгчид

Трассын дагуу талбайд 5 зүйл могой, 7 зүйл гүрвэл нийт 12 зүйл мөлхөгч амьтан тэмдэглэгджээ. Энд монгол орны хамгийн том гүрвэл болох Замба гүрвэл /*Laudakia stoliczana*/, цоохор хонин гүрвэл /*Phynoccephalus versicolor*/, төмөр гүрвэл /*Alsophylax pipiens*/, нохой гүрвэл /*Teratoscincus przewalskii*/, могой гүрвэл /*Eramias multiocellata*/, говийн гүрвэл /*Eramias przewalskii*/, загалт гүрвэл /*Eramias mermiculata*/, нарийн могой /*Coluber spinalis*/, тэмээн сүүл могой /*Eryx tataricus*/, сум могой /*Psammophis lineolatus*/, рашааны могой /*Elaphe dione*/, бамбай хоншоорт могой /*Gloydus halys*/ бий.

Энэ нутгийн мөлхөгчдийн зүйлийн бүрэлдэхүүнд Төв азийн унаган амьтад зонхилох байрыг эзэлдэг. Трассын дагуу нутагт тэмээн сүүл могой, нарийн могой зэрэг 2 зүйл мөлхөгч Монгол орны Улаан номонд, CITES-ийн II хавсралтад тэмээн сүүл могой тус тус бичигдсэн байна. Гүрвэлүүдээс геккон гүрвэлийн овгийн төмөр гүрвэл, нохой гүрвэл хоёр шөнийн амьдралтай. Бусад гүрвэлүүд нь өдрийн идэвхтэй.

Хүснэгт 9. Судалгааны талбайд тархсан Мөлхөгчдийн зүйлийн бүрдэл, хамгааллын статус

№	Зүйлийн нэр			
	Латин	Монгол	Англи	Тохиолдоц
1	<i>Alsophylax pipiens</i>	Төмөр гүрвэл	<i>Squeaky pygmy gecko</i>	элбэг
2	<i>Teratoscincus przewalskii</i>	Нохой гүрвэл	<i>Plata-tailed gecko</i>	ховор
3	<i>Laudakia stoliczana</i>	Замба гүрвэл	<i>Mongolian agama</i>	ховор
4	<i>Phynoccephalus versicolor</i>	Цоохор хонин гүрвэл	<i>Toad-headed agama</i>	элбэг
5	<i>Eramias przewalskii</i>	Говийн гүрвэл	<i>Gobi racemumer</i>	элбэг
6	<i>Eramias multiocellata</i>	Могой гүрвэл	<i>Multiocellated racenunner</i>	элбэг
7	<i>Eramias mermiculata</i>	Загалт гүрвэл	<i>Wariegated racenunner</i>	элбэг
8	<i>Eryx tataricus</i>	Тэмээн сүүл могой	<i>Tatary sand boa</i>	ховор
9	<i>Coluber apinalis</i>	Нарийн могой	<i>Slender racer</i>	ховор
10	<i>Elaphe dione</i>	Рашааны могой	<i>Pallas's Coluber</i>	элбэг
11	<i>Psammophis lineolatus</i>	Суман могой	<i>Steppe ribbon snake</i>	ховор
12	<i>Aqkistodon halys</i>	Бамбай хоншоор могой	<i>Halys (Central Asian) viper</i>	элбэг

2.9.3. Шувууд

Шувуудын зүйлийн жагсаалт, тоо толгойн тойм мэдээллийг боловсруулах зорилгоор төслийн талбай болон ойр орчимд шувуудын бүртгэлийг хийхэд нийт 6 баг, 8 овгийн 31 зүйлийн 274 (ойролцоогоор) бодгалийг ажиглаж бүртгэсэн байдаг. Төслийн талбай болон ойр орчимд 2 ажиглагч харууц цэгийг 3 байршилд сонгож 30 минутын хугацаанд тасралтгүй ажиглалт хийснээс гадна маршрутын дагуу алхаж ажигласан амьтдыг бүртгэсэн.

Хүснэгт 11. Төслийн талбайд бүртгэсэн зүйлийн жагсаалт

№	Монгол нэр	Шинжлэх ухааны нэр	Кэмп	Уурхай орчим	Статус	Амьтны тоо
GALLIFORMES-ТАХИА						
1	Эрээн хавирга хахилаг	<i>Alectoris chukar</i>		11	Суурин	11
ACCIPITRIFORMES -ХАРЦАГА						
2	Нөмрөг тас	<i>Aegypius monachus</i>		2	Суурин	2
3	Цармын бүргэд	<i>Aquila chrysaetos</i>		1	Суурин	1
4	Ооч ёл	<i>Gypaetus barbatus</i>		3	Суурин	3
5	Шилийн сар	<i>Buteo hemilasius</i>		1	Суурин	1
6	Сохор элээ	<i>Milvus migrans</i>		1	Нүүдлийн	1
FALCONIFORMES – Шонхортон						
7	Идлэг шонхор	<i>Falco cherrug</i>		3	Суурин	3
8	Начин шонхор	<i>falco tinnunculus</i>		1	Суурин	1
PASSERIFORMES -БОР ШУВУУ						
9	Хон хэрээ	<i>Corvus corax</i>		2	Суурин	2
10	Хар хэрээ	<i>Corvus corone</i>	13		Суурин	13
11	Алаг шаазгай	<i>Pica pica</i>	2		Суурин	2
12	Адууч чогчиго	<i>Oenanthe oenanthe</i>	1		Нүүдлийн	1
13	Дэрсний жиргэмэл	<i>Alauda cheleensis</i>		6	Суурин	6
14	Монгол болжмор	<i>Melanocorypha mongolica</i>		8	Суурин	8
15	Шоорон эвэрт болжмор	<i>Eremophila alpestris</i>	4	12	Суурин	16
16	Хөх цэгцгий	<i>Motacilla alba</i>	2		Нүүдлийн	2
17	Чээжмэгт галсүүлт	<i>Phoenicurus erythrogastres</i>	1		Суурин	1
18	Хадны бор шувуу	<i>Petronia petronia</i>		16	Суурин	16
19	Хээрийн бор шувуу	<i>Passer montanus</i>	8	23	Суурин	31
20	Загийн бор шувуу	<i>Passer ammodendri</i>		4	Суурин	4
21	Оронгийн бор шувуу	<i>Passer domesticus</i>	34	21	Суурин	55
22	Бор цэгцүүхэй	<i>Linaria flavirostris</i>	19		Нүүдлийн	19
23	Монгол божирог	<i>Montifringilla davidiana</i>	3		Суурин	3
24	Шар хөмсөгт хөмрөг	<i>Emberiza cioides</i>	2		Нүүдлийн	2
25	Монгол хулан жороо	<i>Podoces hendersoni</i>	1	1	Суурин	2
26	Асрын алтан хараацай	<i>Hirundo rustica</i>	2		Нүүдлийн	2
27	Бөөвөлжин өвөөлж	<i>Upupa epops</i>		3	Нүүдлийн	3
OTIDIFORMES- ТООДОГ						
28	Жороо тоодог	<i>Chlamydotis macqueenii</i>		1	Нүүдлийн	1
PTEROCLIFORMES-НОГТРУУ						
29	Монгол ногтруу	<i>Syrhaptes paradoxus</i>	2	50	Суурин	52
STRIGIFORMES- УУЛЬТАН						
30	Хотны бүгээхэй	<i>Athene noctua</i>		2	Суурин	
COLUMBIFORMES-ТАГТАА						
31	Хадны тагтаа	<i>Columba rupestris</i>	8		Суурин	8

Нийт зүйлийн тоо	15	21		3
Нийт бодгалийн тоо	102	172		274

Судалгааны талбайд бүртгэгдсэн зүйлүүдээс 22 буюу 73 хувь нь суурин, 9 буюу 27 хувь нь нүүдлийн зүйл байна.

2.10 Нийгэм эдийн засгийн төлөв байдал

Энэхүү ЦДАШ-ын трасс нь Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутаг орших Баянхондийн уурхайгаас Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутгаар дайрч Нарийн Сухайт уурхайн дэд станц хүрнэ. Өөрөөр хэлбэл, 2 аймгийн тус бүр нэг сумын нутгийг дайран өнгөрч байна. Эдгээр сумдын нэг онцлог нь аль аль нь аймгийн төвөөсөө 270-310 км орчим алслагдсан, БНХАУ-тай тодорхой зурваст хиллэдэг, аймгууддаа хамгийн том газар нутагтай, хүн ам харьцангуй сийрэг суурьшдаг, нийт газар нутгийн тодорхой хувийг Улсын тусгай хэрэгцээний газар нутаг буюу Улсын тусгай хамгаалалттай газрууд эзэлнэ.

ЦДАШ-ын трасс дагуух суурин газрууд нь Монгол орны нийтлэг шинжийг агуулсан мал аж ахуйг голлосон эдийн засагтай. Шинэжинст, Гурвантэс сумдын төвд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах (сүү цагаан идээ, арьс шир, ноос, ноолуур боловсруулах) болон хүнсний зүйл, гурилан бүтээгдэхүүн боловсруулах цехүүдтэй. Харин аймгийн төв зэрэг томоохон суурьшлаас алс тул Гурвантэс сумын иргэд голлож Хятад улсаас, харин Шинэжинст сумын иргэд аймгийн төв, нийслэлээс хүнс бараа таваар авч ирж, ард иргэдийнхээ хэрэгцээг хангах жижиг худалдааны сүлжээ нэлээд хөгжсөн. Гэхдээ эдгээр нь эдийн засагт зонхилох байр суурь эзэлж чаддаггүй. Ингээд ЦДАШ-ын трасс дайрч буй аймаг, сумдын нийгэм эдийн засгийн талаар товч авч хүргэе.

2.10.1 Баянхонгор аймаг, Шинэжинст сумын нийгэм, эдийн засаг

Баянхонгор аймаг. Баянхонгор аймаг нь Төв халхын өвөрмөц соёл иргэншлийн гал төвболохын хувьд Монгол орноор аялж, Монгол ахуйг үзэж сонирхох, судлах сонирхолтой гаднын зочид, жуулчдад хамгийн сонирхолтой бүс нутаг юм. Тус аймаг нь Монголын байгалийн бүх муж, бүсийн төлөөлөл болох хангай, тал хээр, говь, цөлийн үзэсгэлэнт байгаль хосолсон байгалийн 3 бүс, цаг агаарын 2 бүсийг хамардаг өвөрмөц сонин нутаг билээ. Баянхонгор аймаг нь Монгол улсын нутаг дэвсгэрийн 7.8 хувийг эзэлдэг томоохон аймгуудын нэг юм.

Нийт газар нутгийн хэмжээ нь 116 мянган км.квадрат. Аймгийн төв Баянхонгор нь Улаанбаатар хотоос 620 км зайтай. Газар нутгийн ихэнх нь далайн түвшнээс дээш 1000-1400 метр өргөгдсөн, хамгийн өндөр цэг нь Их Богд уул 3957м, хамгийн нам доор газар Ингэн хөөврийн хотгор д.т.д 700 м өргөгдсөн. Өмнө талаараа БНХАУ-тай 140 км нутгаар хиллэсэн, 116 мянган хавтгай дөрвөлжин км нутагтай.

Тус аймаг нь анх 1942 онд 16 сум, 112 баг, 11.8 мянган өрх, 41.8 мянган хүнтэй байгуулагдаж байсан бол одоо 20 сумын 99 багт хамаарах 21.8 мянган айл өрхийн 85.8 мянган хүн амтай болсон байна. Аймаг байгуулагдсан үеэс аймгийн төв Бөмбөгөр, Баян-Овоо, Галуут сумдын нутагт шилжин байршиж, одоогийн оршин буй төвдөө 1961 онд суурьшсан байна. Хүн амын ихэнхийг халхчууд зонхилдог.

Шинэжинст сум. Говь-Алтай нурууны үргэлжлэл тэгш өндөрлөгт Баянхонгор аймгийн Шинэжинст сум нь аймгийн төвөөс баруун урагш 270 км-д байрлах хамгийн алслагдсан газар юм. Тус сум 4 багт нийт 600 өрхийн 2300 хүн амьдардаг.

Говь Алтай нурууны үргэлжлэл тэгш өндөрлөгт далайн түвшнээс дээш 2000м-т

өргөдсөн уул нуруу, хяр, толгод, уудам говь тал, хөндий, хотос хоолой бүхий 1.8 сая га газар нутагтай. Энд далайн түвшнээс 2557 м өндөрт өргөдсөн Залаа Жинст, өмнө хэсэгт далайн түвшнээс дээс 2480м-т өргөдсөн СэгсЦагаан богд уул тус тус ноёлон төв болон баруун Монголын хамгийн нам дор газар болох Ингэн Хөөврийн Говь /696.5 м/, Толь булаг /729 м/ зэрэг хотос хоолойнууд, Эхийн гол, Зуун мод зэрэг баян бүрд газрууд ба Баян төхөм, Баян овоо, Тахилгат, Хайрхан, Хүж хад, Цагаан хаалга, Дөш хайрхан, Ногоон цавын хоолой, Жарт Далтын гайхамшигт хөв тогтсон Бурхантын цохио зэрэг байгалийн үзэсгэлэнт газруудтай. Түүнчлэн Говийн Их дархан цаазат газар ба Говь гурвансайхан байгалийн цогцолборт газрын нутаг дэвсгэрийн хэсэг хамаарагддаг.

Сумын нутгийн 25% буюу 400 га орчим талбайг заган ой эзлэхээс гадна тоорой, хайлаас, жигд, сухай зэрэг олон төрлийн мод ургана. Бэлчээрийн ургамлын хувьд Ар гүн, Ховоот, Залаа жинстийн нуруу тэдгээрийн бэл хормой орчмоор монгол өвс, хялгана, ерхөг, тэсэг, таана, хөмөл, баглуур бүхий хээржүү цөл тарах ба 45 зүйл цэцэгт ургамалтай, нэг га талбайд 173кг ноогдох ургацтай. Харин Баянбулаг, Мандал, Задгай, Оёдол, Төгрөг, Баян аараг зэрэг цав толгодоор хөмүүл, бударгана, шар мод зонхилсон 52 зүйл бэлчээрийн ургамалтай, нэг га- д 290кг ургацтай, үүнээс мал иддэг хэсэг нь 83 кг буюу голдуу тэмээнд тохиромжтой жинхэнэ цөлийн бэлчээр болно.

Сумын эдийн засгийн үндэс нь мал аж ахуй. Сумын хэмжээнд нийт 52746 мян. толгой малтай. Үүнээс 44141 толгой нь ямаа, 5563 нь хонь, 2181 нь тэмээ, үлдсэн нь үхэр, адуу болно. Дугуйлан, хурал цуглаан, үдэшлэг уулзалт зэрэг бүх л соёл урлаг, мэдээллийн арга хэмжээнүүд зохиогддог Соёлын төвтэй. 465 хүүхэд, 18 багш, 11 ажилчин ажилтнуудтай, 120 хүүхдийн дотуур байр бүхий Ерөнхий боловсролын бүрэн дунд сургуультай. 50 хүүхдийн цэцэрлэгтэй. Сумын хэмжээнд 13 ортой, 21 эмч, эмнэлгийн ажилтантай их эмчийн салбар ажилладаг. Мөн цаг уурын өртөө ажиллана. 1990 оноос хойш сумын мал эмнэлэг хувьчлагдаж, одоо хувийн мал эмнэлгийн “Зах гурван ембүү” ХХК ажилладаг. Малыг эмчлэх, урьдчилан сэргийлэг бүхий үйл ажиллагааг хариуцна. Сумын төвд “Залаа хайрхан” хүнс барааны дэлгүүр, оёдлын “Дөл” хоршоо, Баялаг, Алтай, Ар тээл зэрэг олон арван худалдаа үйлчилгээний дэлгүүр ажиллаж байна. 4 шатахуун түгээх станц ажиллаж байна.

2.10.2. Өмнөговь аймаг, Гурвантэс сумын нийгэм, эдийн засаг

Өмнөговь аймаг. Тус аймаг 1931 онд байгуулагдсан, 165.4 мян.км² газар нутагтай.

Манай улсын бусад аймаг, хотуудаас хамгийн том газар нутагтай. Аймгийн нутаг баруун захаас зүүн зах хүртэл 700 км урт, хамгийн хойд цэгээс өмнө цэг хүртэл 400 км орчим зайтай. Тус аймаг өмнө талаараа БНХАУ-тай, баруун, баруун хойд, хойд, зүүн талаараа Баянхонгор, Өвөрхангай, Дундговь, Дорноговь аймгуудтай тус тус хиллэнэ. Аймгийн төв Даланзадгад хот Улаанбаатар хотоос өмнө тийш 553 км зайтай. Тус аймаг засаг захиргааны 15 нэгж буюу сумдтай. Нийт хүн амын тоо 47300. Хүн амын нягтшил 0.28 буюу сийрэг. Аймгийн төв Даланзадгадад хүн амын 31,6 орчим хувь нь, үлдэж буй 68.4% нь сумын төв, хөдөөд суурьшдаг.

Сүүлийн жилүүдэд аймгийн нийт хүн амд эзлэх залуу хүн амын хувийн жин илүү байна. Сүүлийн 7 жилийн хугацаанд аймгийн төв Даланзадгад, Ханбогд, Гурвантэс сумын хүн ам харьцангуй өссөн. Сумдын нийт өрхийн 80-98% нь одоо амьдран сууж буй сум, орон нутгийн уугуул өрхүүд юм. Энд таван өрх тутмын нэг нь эмэгтэй тэргүүлэгчтэй өрх байгаа нь улсын дундаж болох 11.2%-иас харьцангуй өндөр. Эдийн засгийн гол тулгуур нь болсон мал сүрэг өссөөр одоо 1 сая гаруй малтай болоод байна. Тэмээ, ямаан сүргийн тоогоор улсдаа тэргүүлдэг.

Өмнөговь чуудын ирээдүй болсон 14000 гаруй хүүхэд багачууд 17 сургууль, 18

цэцэрлэгт сурч хүмүүждэг. Аймгийн хэмжээнд 24 эмнэлэг эрүүл мэндийн үйл ажиллагаа явуулж байгаагийн нь улсынх, 3 нь хувийнх юм. Эмнэлгүүдийн хэмжээнд 500 гаруй эмч мэргэжилтнүүд ажилладаг. Энэ аймагт сар улирлаар нээгддэг Гашуун сухайт болон Шивээ хүрэнгийн улсын хилийн боом ажилладаг.

Гурвантэс сум. Гурвантэс сум нь аймгийн төвөөс баруун тийш, хамгийн хол алслагдсан сум юм. Улаанбаатар хотоос 870 км, аймгийн төвөөс 320 км зайтай.

Монгол улсын Бүсчилсэн хөгжлийн ээлжит зорилгын хүрээнд Хангайн бүсийн дэд бүтцийн Босоо тэнхлэгийн автозам Гурвантэс сумын нутгаар дамжин Шивээ Хүрэнгийн хилийн боомтоор баруун хойт Хятадын автозамын сүлжээнд холбогдоно. Мөн зам тээврийн дэд бүтцийн чухал хэсэг болох агаарын замын талаар анхааран үзэж Даланзадгадад Олон улсын нисэх онгоцны буудал барих хэтийн төлөвлөгөөтэй ба одоо Гурвантэс сумын Хөвхийн хөндийн Овоотын нүүрсний уурхайн ээлжийн ажилчдад үйлчлэх зориулалттай “Саус гоби сэндс” ХХК-ийн захиалгаар баригдсан нисэх буудал ажилладаг. Овоотын уурхайгаас Шивээ хүрэн хүртэл МАК ХХК-ийн нүүрс тээвэрлэлтийн зориулалттай хатуу хучилттай зам баригдан ашиглагдаж байна. Мөн Гурвантэс сум, Овоотын хилийн отряд, энэ орчмын уул уурхайн компаниудыг Хятадын хилийн боомтоос цахилгааны шугам татаж, эрчим хүчээр хангадаг.

Шивээхүрэн боомт нь байнгын ажиллагаатай бөгөөд “МАК ХХК-ийн захиалгаар Овоотын ордоос хил хүртэл нүүрс тээвэрлэлтийн зориулалттай төмөр зам барихаар төлөвлөсөн байна. Сумын хэмжээнд хувийн хэвшлийн 2-3 аж ахуй Дунд голын давсыг гар аргаар олборлон арьс шир боловсруулах, малын тэжээлийн зориулалтаар зах зээлд нийлүүлдэг. Мөн тэмээ хонины ноосыг гар аргаар боловсруулах “Говь булаг” нэртэй нөхөрлөл үйл ажиллагаа явуулдаг.

Цаашид Олон Овоот, Алтан уулын цагаан шар алтны ордыг бүрэн ашиглах, Дунд голын давсыг иоджуулж аймгийн хүн амын хэрэгцээнд зориулж үйлдвэрлэх, тэмээ ямааны ноосны анхан шатны боловсруулалт хийх үйлдвэрлэл байгуулагдана. Овоотын чулуу нүүрсний уурхайг түшиглэн исэлдсэн нүүрс ашиглан брикетэн түлш үйлдвэрлэх, уурхайн гүн хэсэгт байгаа ил аргаар олборлох боломжгүй чулуу нүүрсийг гидрогенжүүлэх, нүүрсний метан хийг ялган олборлох, чулуу нүүрсийг коксжуулах зэрэг эрчим хүч болон химийн үйлдвэрүүд байгуулах ирээдүй ч харагдаж байна. Харьцангуй усны нөөц багатай газар юм. Иймээс нутгийн иргэдийг усны зөв хэрэглээнд сургах, аливаа үйл ажиллагааг байгаль орчинд ээлтэй технологиор явуулах, булаг шанд, гол горхи зэрэг ил урсцыг хамгаалах, усны нөөцийг хэвийн, бохирдолгүй байлгах явдал чухал юм.

Уурхайн баруун захад Хуршуутын Хайртын баруун, зүүн, дунд булаг нэртэй унд ахуйн стандарт хангах цэвэр ус бүхий булагтай бөгөөд энд 1980-аад оноос сумын болон цэргийн отрядын хүнсний хэрэгцээнд ногоо тарьж эхэлсэн. Одоо ч амжилттай ажиллаж байна.

1967 онд их эмчийн салбартай болж, 2003 онд эмнэлгийн 2 давхар барилга ашиглалтад орсноор одоо их эмч 2, бага эмч 4, сувилагч 6, эм зүйч 1 орон тоотойгоор эрүүл энхийн төлөө ажиллаж байна. Эмнэлгийн эдийн засгийн бааз харьцангуй сайн. Энд эрүүл мэндийн ерөнхий үзлэг, хэвтэх болон гэрээр эмчилгээ хийгддэг. Монгол улсын Боловсролын хуульд зааснаар 8-18 насны хооронд хүүхдүүдэд бага боловсролыг 4 жилээр, суурь боловсролыг 8 жилээр, бүрэн дунд боловсролыг 10 жилийн хугацаанд олгодог. Гурвантэс суманд суурь боловсролын 8 жилийн дунд сургуультай. Энд 75 хүүхдийн дотуур - байр, гал тогоотой. Хөдөөгөөс ирж хүүхдүүдтэйгээ уулзахад зориулсан 4 ортой зочид буудалтай. Энд бага дунд ангийн нийт 585, сурагчид, 28 багштайгаар хичээллэж байна. 4

бүлэгтэй хүүхдийн цэцэрлэгтэй. Сумын мал эмнэлэг, үржлийн алба нь анх 1954 он байгуулагдаад 1999 он хүртэл үйл ажиллагаа явуулсан. Харин 1999 оноос хувьчлагдаж их эмч, бага эмч нарын үүсгэн байгуулсан “Баясах хайрхан” бүрэн хариуцлагатай нөхөрлөл болон үйл ажиллагаа явуулж байна. Энд нутгийн малын дунд түгээмэл тархалттай малын өвчнийг анагаах, урьдчилан сэргийлэх вакцинд хамруулах, мал сүргийг нийтэд нь эрүүлжүүлэх, угаах, малын үүлдэр угсаа сайжруулах зэрэг үйл ажиллагаа явуулж байна. Сүүлийн жилүүдэд болж байгаа хаврын зуднаар мал их хорогдсон байна.

ГУРАВ. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ

3.1 Төслийн болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим

Төслийн болзошгүй нөлөөллийг тогтоохдоо магадлан жагсаах аргыг ашиглаж, үр дүнг дараах хүснэгтэд үзүүлэв. Энэ арга нь төсөл хэрэгжих үед тухайн нөлөөлөл байгаа эсэх дээр тулгуурладаг ба хэрэв тухайн нөлөөлөл байвал "х"-ээр тэмдэглэдэг. Ингэхдээ тухайн нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим зэргийг тодруулах, мөн уг нөлөөлөл байгаль орчин, экосистемийн тэнцвэрт байдал, орон нутгийн нийгэм, эдийн засагт хэрхэн нөлөөлөх (шууд, шууд бус, эргэж нөлөөлөх, буцалтгүй нөлөөлөх, давхардах эсэх) байдлыг үзүүлдэг. Төслийн байгаль орчинд үзүүлэх болзошгүй нөлөөллийн үнэлгээг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 12. Төслийн болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим

Байгаль орчны үзүүлэлтүүд	Нөлөөлөл			Хугацаа		Давталт		Эрчим		
	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
1. Байгалийн экосистемийн өөрчлөлт										
Газрын доорх урсцын өөрчлөлт										
Хөрсний элэгдэл, эвдрэл	X		X				X			X
Ургамлын бүтцийн өөрчлөлт	X		X				X		X	
Геологийн тогтцын өөрчлөлт										
Зэрлэг амьтдын орон зай		X			X		X		X	
Уур амьсгалын бичил өөрчлөлт										
2. Байгалийн нөөц ашиглалт										
Газрын гадаргын нөөц, баялаг	X		X				X			X
Бэлчээрийн байдал	X		X				X			X
Эрдэс, түүхий эд, нөөц	X		X				X			X
Эрчим хүчний нөөц	X			X			X			X
3. Байгаль орчны чанарын өөрчлөлт										
Газрын доорх усны чанарын өөрчлөлт										
Гадаргын усны чанарын өөрчлөлт										
Агаарын бохирдол	X			X			X			X
Хөрсний бохирдол	X			X			X			X
Дуу чимээ, шуугианы нөлөө										
4. Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палентологийн олдвор										
Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх	X				X		X	X		
Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	X				X		X		X	
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх	X				X		X			X
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх										
Археологи, палентологийн олдворт нөлөөлөх										
5. Эдийн засаг, нийгмийн асуудал										
Ажлын байр нэмэгдэх	X				X		X			X
Орон нутгийн орлого нэмэгдэх	X				X		X		X	
Хувийн өмчийн болон татварын орлого	X				X		X		X	
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	X			X			X			X
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	X				X		X		X	
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх	X				X		X			X
6. Бусад нөлөөлөл										
Шороон зам харилцаа, машины хөдөлгөөн шилжилтээс болж хөрс элэгдэж, эвдрэх	X				X		X	X		
Агаарын бохирдлын бага зэргийн тухайлсан эх үүсвэр бий болох	X				X		X		X	
Ахуйн бохир ус хөрсөнд нэвчиж, хөрс ба грунтын усыг бохирдуулах	X			X			X			X
Ахуйн хаягдал, хогийн цэгийн зохих шаардлагын дагуу зайлуулж, устгаагүйгээс байгаль орчин бохирдох, эвгүй үнэр гаргах, шавж үржих	X			X		X				X
Хүчтэй салхи, тоосжилт, байгалийн гамшиг		X		X		X				X
Дүн	25	3		4	22		23	7	7	13

Байгалийн баялаг, нөөц ашиглалт:

Төслийн үйл ажиллагаанд байгалийн баялаг, нөөц ашиглахгүй.

Байгаль орчны чанарын өөрчлөлт:

Төсөл хэрэгжих үе шатанд ЦДАШ-ын түүхий эд материал тээвэрлэхэд тоос богино хугацаагаар (өдрийн цаг) гарч ажиллагсдын эрүүл мэндэд нөлөөлөх, ойр орчмын хөрсний бүтэц өөрчлөгдөх, улмаар ургамлын бүрхэвчид нөлөөлж болох талтай. Үйл ажиллагааны үед машин техникийн хөдөлгүүрийн дуу чимээний нөлөөллийг эрчмийн хувьд дунд гэж тооцов.

Байгалийн өнгө төрх түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палентологийн олдвор:

Төслийн трассын дагуу дайран өнгөрч буй Ундайн голын зүүн эрэгт ханан хаданд дүрсэлсэн нэлээд хэдэн зураг бий. Төслийн талбай нь Говийн Бага дархан цаазат газрын Б хэсгийн орчны бүсээс 50 км-т байршдаг бүтээн байгуулалттай холбогдсон үйл ажиллагаа нь тусгай хамгаалалттай газар нутагт шууд нөлөөлөл үзүүлэхгүй боловч хүн болон машин техникийн хөдөлгөөн ихсэх, дуу чимээ үүсэх, тоосжилт тархах зэргээр шууд бус сөрөг нөлөө үзүүлж болзошгүй юм.

Эдийн засаг нийгмийн асуудал:

Үйл ажиллагаа нь улс орон нутгийн төсөвт тодорхой хэмжээний орлого оруулах бөгөөд ажлын байр бий болж, тэдний амьжиргаанд тус нэмэр болох сайн талтай юм. Эдгээр нь шууд бөгөөд урт хугацааны эерэг нөлөөлөлд хамаарна.

Бусад нөлөөлөл:

Энэ төрлийн нөлөөлөлд газар ашиглалт болон ахуйн хаягдалтай холбогдолтой зүйлүүдийг оруулав. Газар ашиглалтын холбоотой нөлөөлөлд хөрсний элэгдэл, байгалийн гамшгийг (хүчтэй салхи, үер, газар хөдлөлт гэх мэт) оруулдаг байна. Төсөл хэрэгжих орчмын цаг уурын станцын мэдээллээс үзвэл хаврын улиралд салхи ихтэй заримдаа 15 м/сек дээш хүчтэй салхилдаг нь түүхий эд тээвэрлэх ажиллагааны үед хөрснөөс суллагдсан их хэмжээний тоос шороо босох, ойр орчимдоо хөрсний элэгдэл, эвдрэлийг улам хүчтэй болгох нөхцөлтэй.

Төслийн үйл ажиллагааны үед байршил, техник-технологийн шийдэл болон төсөл хэрэгжих үеийн байгаль орчны асуудлыг тус тусад нь авч үзэн магадлан жагсаах аргыг хэрэглэнтүүний нөлөөллийн үр дагаврыг “бага”, “дунд”, “их” гэсэн утгуудын аль тохирохыг (Х) гэж тэмдэглэв. Төслийн талбай дээр ажиллах үед тоос шороо дэгдэхээс хамгаалах, салаа зам гаргах зэргээр хөрсний эвдрэлийг ихэсгэхгүй байх шаардлагатай.

ДӨРӨВ. 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт нь тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, үнэлгээний тайлангийн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллахыг зорино. Үүнд:

- ✓ Төслийн хэмжээнд хамрагдаж байгаа талбайн хэмжээнд байгаль орчны хуулийн нийцлийг хангах;

- ✓ Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний заалтуудыг хэрэгжүүлэх;
- ✓ Байгаль орчны төлөвлөгөөг хэрэгжүүлэх хамаарал, хамрах хүрээг тодорхойлох;
- ✓ Төслийн үйл ажиллагаанд оролцогч байгууллагуудын үйл ажиллагаандаа баримтлан хэрэгжүүлэх байгаль орчны асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг тодорхойлох;
- ✓ Орон нутагтай байгаль хамгаалах ажилд хамтран ажиллах;
- ✓ Талуудын оролцоог хангах, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт олон нийтийн оролцоог хамруулах, тайлагнах тогтолцоог сайжруулах;

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгасан болно. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласнаар доорх зорилтуудыг хангана. Үүнд:

- Байгаль орчны хууль тогтоомжийн холбогдох зүйл заалт, журам заавар, стандартын шаардлагад нийцүүлэн төслийн үйл ажиллагааг явуулна.
- Байгаль орчны менежментийн асуудлаар БОННУ-ний тайланд боловсруулан тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмжүүдийг хэрэгжүүлнэ.
- Ажилчид байгаль орчны хамгаалах асуудалтай холбоотой үүрэг хариуцлагаа ойлгосон байх, сургалтад хамрагдах боломжтой болно.
- Байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, эрсдэлийг урьдчилсан тооцсоноор байгальд шууд болон шууд бус хэлбэрээр үзүүлэх нөлөөллийг бууруулах, байгаль орчны төлөв байдлыг хадгалж, хамгаална.
- Сум орон нутгийн удирдлага, хяналтын байгууллага, ард иргэдтэй байгаль хамгаалах асуудлаар зөвлөлдөж, тэдний саналыг авч хамтран ажиллах нөхцөл бүрдэнэ. Тус төлөвлөгөөний гол зорилго нь БОННУ-ний тайлангийн “Бүлэг 5”-т тодорхойлсон гол сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгахад оршино. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө нь төлөвлөж буй төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийг шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамж, баримтлах дүрэм журам, стандартуудын хамт Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ нь заавал мөрдөн ажиллах баримт бичиг юм.

Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутгаас Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутгаар дайран өнгөрөх “М Си Эс Интернэйшнл” ХХК-ийн “Нарийн Сухайт – Баянхөндий 242 км 110 кВ ЦДАШ, 2х16 МВА дэд станц төсөл”-д 2025 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд зарцуулах нийт зардлыг нэгтгэн дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт13 . Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын нэгдсэн дүн

№	ЗАРДЛЫН ТӨРӨЛ	2025 он /сая.төг/
1	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө	6.59
	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	2.34
	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1.25

	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	3.0
2	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1.45
	Агаарын чанар	0.065
	Хөрсний төлөв байдал, чанар	0.068
	Усны чанар	0.075
	Ургамлын аймаг	0.5
	Амьтны аймаг	0.74
	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал сая.төг	8.04

4.1 БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийг шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамж, баримтлах дүрэм журам, стандартуудын хамт нэгтгэн харуулж буй төсөл хэрэгжүүлэгчийн заавал хэрэгжүүлж, мөрдөж ажиллах ёстой баримт бичиг юм.

Байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг холбогдох журам, ерөнхий үнэлгээний дүгнэлтэд заасан шаардлагын дагуу урьдчилсан байдлаар тодорхойлж тусгав. Энэхүү төлөвлөгөөнд тусгасан байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүд нь зөвхөн төслийн гүйцэтгэгч Баянхонгор аймгийн Шинэжинст, Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутаг төслийг хэрэгжүүлэхэд зориулагдсан болно. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний ихэнх хэсэг Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөртэй нягт уялдах тул төслийн хэрэгжилтийн бүхий л хугацааны туршид газрын доорх ус, хөрсний чанар, ургамалжилт, амьтны аймагт гарч байгаа өөрчлөлтүүдийг тухай бүрт нь шинжилж, холбогдох арга хэмжээг жил бүрийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хүрээнд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.

4.1.1 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

4.1.1 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ										
№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд		Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, сая.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Агаар орчин										
1	Тоосжилт үүсэх	Материал тээвэрлэлт	- Олон салаа зам үүсэхээс сэргийлэх, замын тоосжилт багасгах, хөдөлгөөнийг төвлөрүүлэхийн тулд үндсэн нэг замтай байх; - Нэг удаагийн тээвэрт 4 ба түүнээс доош тооны техник хэрэгсэл зорчих; - Зам талбайг услах;	Бүтээн байгуулалтын үед удирдлага зохион байгуулалтын түвшинд	Удаа	Үйл ажиллагааны зардлаас		Бүтээн байгуулалтын үед	MNS 5010-2001 Тоос. Ажлын байрны агаар дахь тоосны агуулгыг хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага. MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага. MNS 5885:2008 Агаар бохирдуулагч бодисын хүлцэх хэм хэмжээ	
2		Салхины хурд ихсэх, шороон шуурга	- Суурийн ажил, тулгуур багана, газардуулагчийн суурилуулах үеийн газар шорооны ажлыг тухайн газруудын их салхи шуургатай болон орчны цаг мэдээнд үндэслэн төлөвлөх, тоос дарах арга хэмжээг шаардлагатай тохиолдол бүрд авч хэрэгжүүлж ажиллах	Бүтээн байгуулалтын үед удирдлага зохион байгуулалтын түвшинд	Удаа	Үйл ажиллагааны зардлаас		Бүтээн байгуулалтын үед		
3		Угсралтын үед ашиглаж байгаа машин механизмын хөдөлгөөн	- Агаарын чанарын хэмжилт хийх	Бүтээн байгуулалтын үеийн болон арчлалт засварын техник хэрэгслүүд	Жил/удаа	Үйл ажиллагааны зардлаас		Бүтээн байгуулалтын үед жилд 1 удаа		

4	Авто машин, техникийн хөдөлгүүр ээс үүсэх хийн бохирдол	Угсралтын ажилд ашиглаж байгаа машин механизмын ажиллагаанаас	- Төслийн бүтээн байгуулалт, барилгын ажилд хэрэглэгдэж буй тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээ, тохируулгыг байнга хийж, хөдөлгүүрээс гарах утааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах	Бүтээн байгуулалтын үеийн болон арчлалт засварын техник хэрэгслүүд	Жил/удаа	Үйл ажиллагааны зардлаас	Улирал бүр	MNS 5013:2009 Бензин хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга, MNS 5013:2009 Бензин хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга, MNS 5014:2009 Дизель хөдөлгүүртэй автомашин. Утааны тортогжилтын зөвшөөрөх дээд хэмжээ ба хэмжих арга
5	Дуу чимээний нөлөөлөл	Хүнд машин механизм ажиллуулах, Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүсэх чимээ, Шөнө оройн цагт ажиллах үед орчны тайван байдал алдагдах	- Орон нутгийн оршин суугчдад урьдчилан мэдээлэх - Ажлын цагийн хязгаар тогтоох (08:00–20:00 гэх мэт)	Төслийн хэмжээнд	Удаа	Зардал шаардахгүй	Бүтээн байгуулалтын үед	Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585 2016
Гадаргын ба газрын доорхи ус, усны чанар								
1	Усны бохирдол	- Машин механизмын хөдөлгөөнөөр үүссэн бохирдол болон хог хаягдал нь үерийн усаар зөөгдөх	- Ахуйн хуурай хог хаягдлын цэг болон шингэн хаягдлыг зайлуулах цэг, машин техникийн зогсоол зэргийг жалга, суваг шуудуунаас хол зайд байрлуулах	Бүтээн байгуулалтын үед ажилчдын түр кемп болон барилгын талбайд	Тоо	Үйл ажиллагааны зардлаар	Бүтээн байгуулалтын үед	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
2		Аюултай хорт бодис алдагдах, машин техникийн шатахуун асгарах, усан орчинд нэвчих	- Асгаралтыг цуглуулан, нэвчсэн бүх хэсгийг бохирдсон хөрс саармагжуулах талбайд хураан, зориулалтын бодисоор саармагжуулна. - Ойролцоох худгуудаас усны дээж авч шинжлүүлэх	Байгаль орчин хариуцсан нэгж эсвэл мэргэжилтэн	Жил/удаа	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгав	Бүтээн байгуулалтын үед жилд 1 удаа	MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. MNS 5667-2:2001 Усны чанар-Дээж авах-2-р бүлэг Дээж авах арга MNS 4867:1999 Усны чанар-Дээж авах-3-р бүлэг Авсан дээжийг зөөвөрлөх, хадгалах арга

3	Нөхөн сэргээлт	Худгуудыг засварлах	- Трассын ойролцоо нөлөөллийн бүсд байгаа засварлах шаардлагатай худгуудыг засварлах, түүнийг сум орон нутагт хүлээлгэх өгөх	Удирдлага Зохион байгуулалтын хүрээнд	Жил/уд аа	Үйл ажиллагааны дотоод төлөвлөлтөөр			Бүтээн байгуулалтын үед жилд 1 удаа	
Хөрсөн бүрхэвч										
1	Хөрсний элэгдэл, эвдрэл үүсэх	Төслийн бүтээн байгуулалтын явцад олон салаа зам гарах хөрсний эвдрэл үүсэх	- Олон салаа зам гаргуулахгүй байх, замын тэмдэг тэмдэглэгээ байршуулах; Олон салаа замыг хааж нөхөн сэргээх, нэгдсэн маршрутыг тогтоох;	Ашиглаж буй түр замуудын хэмжээнд	-	-	-	0.5	Бүтээн байгуулалтын үед эхний жилд	MNS 4597:2014 Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага MNS 4596:2014 Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм
2	Хөрсний бохирдол үүсэх	Ахуйн гаралтай хатуу хог хаягдлыг ил задгай хаях	- Хогийн цэг, битүү тагтай хогийн сав байрлуулах, ахуйн хог хаягдлыг ангилан түр хадгалах цэгт хурааж, эрх бүхий ажилтнаас зөвшөөрөл авч тээвэрлэх;	Бүтээн байгуулалтын үед ажилчдын түр кемп болон барилгын талбайд	м3	0.17	2	0.34	Бүтээн байгуулалтын үед	Хог хаягдлын тухай хууль Ахуйн хог хаягдлын тээвэрлэлт. Ангилал. Ерөнхий шаардлага MNS 5344:2003
3		Шатах, тослох материал хөрсөнд асгарах, гадаргын идэвхт нийллэг бүтээгдэхүүнээр хөрс бохирдох /бензин, дизель түлш/	- Асгаралтын сургалт явуулах, журам танилцуулах ажлыг нийт ажилчдад зохион байгуулна. Шатах тослох материалыг хөрсөн дээр шууд тавихгүй байх	Бүтээн байгуулалтын үед удирдлага зохион байгуулалтын түвшинд	Жил/уд аа				Бүтээн байгуулалтын үед	Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850 2019
4		Шаардлага хангахгүй нийтийн бие засах газраас үүсэх бохирдол	- Нийтийн бие засах газрыг стандартын дагуу байгуулах, ариутгал, халдваргүйжүүлэлтийг улирал тутамд гүйцэтгэнэ.	Бүтээн байгуулалтын үед ажилчдын түр кемп болон барилгын талбайд	Дотоод үйл ажиллагааны зардлаар				Бүтээн байгуулалтын үед	Нүхэн жорлон, угаадасны нүх техникийн ерөнхий шаардлага MNS 5924 2008
5		Хөдөлгөөнт техникийн засвар үйлчилгээнээс хөрс бохирдох	- Засвар үйлчилгээний зориулалтын талбай бэлтгэн, дайрга дэвсэн хөрснөөс тусгаарласан байна.	Бүтээн байгуулалтын үед ажилчдын түр кемп	Дотоод үйл ажиллагааны зардлаар				Бүтээн байгуулалтын үед	Хөрс, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль (2012-05-17) 5.6-р зүйл заалт

				болон барилгын талбайд			
6	Биологийн нөөц хомсдох	Хөрсний биологийн нөөц хомсдох, үржил шим нь алдагдах, хуурайших	- Хөрсний мониторинг судалгааг мэргэжлийн байгууллагаар жилд 1 удаа хийлгэж, үр дагаврыг тогтмол хянах	Бүтээн байгуулалтын үед ажилчдын түр кемп болон барилгын талбайд	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгав.	Бүтээн байгуулал тын үед жилд 1 удаа	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5915:2008
Ургамлан нөмрөг							
1	Ургамлын талхагдал , хууль бус байгалийн ургамлыг түүж бэлтэх	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс түүний ойр орчмын ургамлан нөмрөг талхлагдах	- Ургамлын мониторинг судалгааг жилд 1 удаа хийлгэж, үр дагаврыг тогтмол хянах	Бүтээн байгуулалтын үед ажилчдын түр кемп болон барилгын талбайд	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгав.	Бүтээн байгуулал тын үед Жилд 1 удаа	Бэлчээрийн газрын хөрсний элэгдэл эвдрэл, ургамлын талхагдлыг тогтоох ерөнхий шаардлага. MNS 5546: 2005 - Ургамлын мониторинг хийх гадаад ба дотоодын судлаачдын гаргасанаргачлал, аргазүйг баримтална.
2		Хууль бус аргаар байгалийн ургамал түүж, бэлтгэх	- Хууль бус байгалийн ургамал түүж бэлтгэхтэй холбоотой санамж, сургалт зохион байгуулна.	Бүтээн байгуулалтын үед ажилчдын түр кемп болон барилгын талбайд	Дотоод үйл ажиллагааны зардлаар	Бүтээн байгуулал тын үед Жилд 1 удаа	Ургамал хамгааллын тухай хууль, Байгалийн ургамлын тухай хууль
3		Ашиглалтын бус талбайд газар шороо хөндөх, олон салаа зам үүсгэх	- Ашиглалтын бус талбайд аль болох техник ажиллуулахгүй, газар шороо хөндөхгүй байх, тогтсон маршрутаар зорчих	Төслийн бүх хугацаанд	Дотоод үйл ажиллагааны зардлаар	Байнга	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
Амьтны аймаг							
1	Амьтны тоо толгой цөөрөх, дайжих	Хөхтөн амьтдын нүүдэл шилжилтэд нөлөөлөх	- Барилгын ажлыг богино хугацаанд гүйцэтгэх, барилгын ажлыг шөнийн цагт гүйцэтгэхийг хориглох	Удирдлага Зохион байгуулалтын хүрээнд	Үйл ажиллагааны дотоод төлөвлөлтөөр	Бүтээн байгуулал тын үед	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Амьтны тухай хууль

2	Ан амьтны тоо толгой цөөрөх	Агаарын шугамын утсан дээр шувуу суух үед хоёр фазын хоорондох утсанд далавч нь фазуудад шүргэх	- “Шувуу үргээх” төхөөрөмж суурилуулах	Төслийн төлөвлөлтийн үе шатанд заавал авч хэрэгжүүлэх	Төслийн төлөвлөлтийн зардлаар				Бүтээн байгуулалтын үед	Уур амьсгалын нөхцөлд зориулж, ГОСТ 15-150 стандартад нийцүүлж үйлдвэрлэсэн Цахилгаан техникийн байгууламжийн дүрэм (ПЭУ) 7 дахь хэвлэл.2003 он
3		Хууль бус ан гөрөө хийх	- Хууль бус ан автай холбоотой зурагт постер, санамж, сургалт зохион байгуулана. Шаардлагатай тохиолдолд Экологийн цагдаагийн албатай хамтран ажиллах;	Төслийн хэмжээнд	Төслийн төлөвлөлтийн зардлаар				Бүтээн байгуулалтын үед	Амьтны тухай хууль
4		Байгалийн зэрлэг амьтан тэжээх, гаршуулах	- Байгалийн зэрлэг амьтан хооллох, барих, тэжээх зэргийг хориглосон зурагт постер мэдээлэл, санамжуудыг нийтэд хүргэх бөгөөд байгаль орчны зааварчилгаанд тухайн зүйлийг анхааруулж, оруулсан байх;	Төслийн хэмжээнд	Төслийн төлөвлөлтийн зардлаар				Бүтээн байгуулалтын үед	Амьтны тухай хууль
Удирдлага, зохион байгуулалтын талаар авах арга хэмжээ										
1	Хүний эрүүл мэнд		- Ажлын байранд анхан шатны тусламж үйлчилгээний иж бүрэн багаж хэрэгслийг авч, байрлуулах;	Ажлын талбар болон ажилчдын кемпэд	Үйл ажиллагааны дотоод төлөвлөлтөөр				Жилд бүр	Хөдөлмөрийн тухай хууль Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Химийн хорт бодисын ангилал ба аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS 4992:2000
2			- Ажиллагсдыг нэг бүрийн хамгаалах хэрэгслээр бүрэн хангах	ЦДАШ-ын бүх ажилчид	Үйл ажиллагааны дотоод төлөвлөлтөөр				Жилд 2 удаа	Хамгаалалтын хувцас ерөнхий шаардлага. MNS (ISO) 13688:2000 Гал түймрээс хамгаалах. MNS 5566-2005
3	Хөдөлмөрийн аюулгүй байдал		- Хөдөлмөрийн аюулгүй байдал, байгаль орчныг хамгаалах, гал түймэр, болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх, нийт ажилтны сургалт зохион байгуулах	Төслийн хүрээнд	тоо	1.5	1	1500	Жил бүр	Хөдөлмөрийн тухай хууль Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль Галын аюулгүй байдлын тухай хууль Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргах журам

4		- Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулах		Үйл ажиллагаан дотоод төлөвлөлтөөр	Жилд 1 удаа	
5		- Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлд дүгнэлт гаргуулах		Үйл ажиллагааны дотоод төлөвлөлтөөр	Жилд 1 удаа	
6	Төслөөс байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл	- Жил бүр тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтийг хангах, биелэлтийг тайлагнах	Төслийн хүрээнд	Үйл ажиллагааны дотоод төлөвлөлтөөр	Жил бүр	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралт- Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам
СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ НИЙТ ЗАРДАЛ				2.34 сая төг		

4.1.2. НӨХӨН СЭРГЭЭЛТ, НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

- Түр кэмп байрлаж байсан хэсгүүдийн хог хаягдлыг бүрэн цэвэрлэх
- Ойр орчмын худаг, уст цэгүүдийг тохижуулж, засварлах
- Талхлагдсан газар нутгийг нөхөн сэргээх, тэгшилж, байгальд ойршуулсан байдлаар хэвийн төлөвт оруулах
- Дээрх ажлуудын үр дүнг орон нутгийн холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөх бөгөөд хүлээлцэх акт үйлдэж баримтжуулах
- “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд төслийн нөлөөллийн бүс нутагт мод тарих, модны хандив өгөх, дэмжлэг үзүүлэх
- Ногоон байгууламжийн ажилд орон нутгийн байгууллагуудын оролцоог хангаж, урт хугацаанд арчлан тордох нөхцөлийг бүрдүүлнэ

4.1.3. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн хэрэгжилтийн явцад газар ашиглалт, барилга угсралтын үйл ажиллагаанаас үүдэн тухайн бүс нутгийн байгалийн экосистем, амьтан ургамлын амьдрах орчинд нөлөөлөх эрсдэлтэй. Иймээс Байгаль орчны үнэлгээний дүгнэлт болон хуулийн шаардлагад нийцүүлэн биологийн олон янз байдлыг хамгаалах, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах зорилго бүхий дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна:

- Усны эх үүсвэрийг сэргээн засварлах
- Амьтны амьдрах орчныг хязгаарлахгүй байх чиглэлээр барилга угсралтын үеийн хөдөлгөөний маршрутыг оновчлох
- Ургамал тарималжуулах
- Судалгаа, шинжилгээний ажилд орон нутгийн экологичид, байгаль хамгаалагчидтай хамтран оролцох
- Байгаль хамгаалах сайн дурын ажлуудыг төслийн нэгжийн зүгээс дэмжих

4.1.4. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭЛТ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус төслөөс орон нутгийн иргэд, оршин суугчид, айл өрх, байгууллагыг нүүлгэн шилжүүлэх шаардлагагүй.

4.1.5. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн хэрэгжилтийн явцад орон нутгийн түүх, соёлын өв, археологийн дурсгалт газар болон тахилгат, шүтээнтэй нутгийн байршилд нөлөөлөхөөс сэргийлэх зорилгоор дараах хамгаалалтын төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.

- Төслийн гүйцэтгэгч, ажилтнуудыг түүх, соёлын өвийг үл хөндөх, хамгаалах чиглэлээр богино хэмжээний сургалтад хамруулах
- Түүхийн дурсгалт газрыг хамгаалах тухай хууль тогтоомжийн талаарх мэдээллийг түгээх
- Орон нутгийн ахмад буурлууд, нутгийн удирдлагын байгууллагын санал зөвлөмжид тулгуурлах
- Түүх, соёлын дурсгал илэрсэн тохиолдолд нэн даруй мэргэжлийн байгууллагад мэдэгдэж, зогсоох ажиллагаа хэрэгжүүлэх

4.1.6. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд батлагдсан аргачлалын дагуу эрсдэлийн үнэлгээний дүнд осол эрсдэл гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хэмжээ, шаардагдах зардал, баримтлах стандартыг энд тусгасан.

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг, сая.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Болзошгүй осол							
1	Тулгуур босгох болон фазын дамжуулагч утас татах үед осол гарах	Ажилчдыг аюулгүй ажиллагааны хувцас хэрэгслээр бүрэн хангах, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх	Төслийн Бүтээн байгуулалтын ажилтнууд	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний зардалд оруулсан.		Байнга	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Цахилгаан станц ба шугам сүлжээний техник ашиглалтын дүрэм, Цахилгаан дамжуулах агаарын шугам, иж бүрэн трансформаторын дэд станц, хийцийн ажлын хөдөлмөр зарцуулалтын нэгж хугацааны норм /БнбД 83-30-21/ MNS6522:2015/ 35-750 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам. Барьж байгуулахад тавигдах шаардлага, MNS 5870:2008 Цахилгаан дамжуулах агаарын шугамын тусгаарлагагүй утас. Техникийн шаардлага
2		Ажилчдад зааварчилгаа өгөх	Бүх ажилчид			Тухай бүрт	
3	Цахилгаан шугмын утас сулрах	Цахилгаан шугмын бүрэн бүтэн байдалд гаргасан хуваарийн дагуу үзлэг хийж тогтмол хяналт тавих	Төслийн хүрээнд	0.25	250.0	Жил бүр	
4	Агаарын шугамын утсан дээр шувуу суух үед хоёр фазын хоорондох утсанд далавч нь фазуудад шүргэх	Полимер бүрхүүл, хөндийрүүлэгчтэй шувуу хамгаалах байгууламж байрлуулах	Төслийн ашиглалтын явцад	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт зардлыг тооцсон			

Гал түймэр							
5	Гал түймэр	Төслийн бүтээн байгуулалтын үе гал түймэртэй тэмцэх багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмж авах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эмнэлэгийн анхан шатны тусламж үйлчилгээний тоноглолуудыг зохих газарт байнга бэлэн байлгах	Төслийн хүрээнд	1.0	1.0	Тогтмол	Галын аюулгүй байдлын тухай хууль Гал түймрээс хамгаалах. MNS 5566:2005
ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ				1.25 сая.төг			

4.1.7. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг, сая.төг	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Болзошгүй осол							
1	Хөрс, ус, агаарын бохирдол. Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл	Хог хаягдлын цэг байгуулах	Барилгын ажлын үеийн түр кемп	1.0	1.0	Бүтээн байгуулалтын үед	Хог хаягдлын тухай хууль MNS 5924:2015 Нүхэн жорлон, угаадасны нүх, Техникийн шаардлага
2		Хаягдал дугуй болон төмрийн хаягдлыг ангилан ялган цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх	Барилгын ажлын үед	-	-	-	
3		Ажиллагсдад хог хаягдлын хууль, эрхзүйн орчин, хог хаягдлын менежментийн чиглэлээр сургалт зохион байгуулах	ЦДАШ дээр ажиллах бүх ажилчдад	1.0	1.0	Жилд 1 удаа	

4		Хог хаягдлын гэрээ байгуулах	Барилгын ажлын үеийн түр кемп	1.0	1.0	Бүтээн байгуулалтын үед	
ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ				3.0 сая.төг			

4.2 БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь төслийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл болон агуулахыг ашиглах явцад гарч болзошгүй эрсдэлийн үед байгаль орчинд бий болох бохирдол, доройтлыг тодорхойлох зорилготой заавал хэрэгжүүлэх баримт бичиг юм. Хяналт шинжилгээний хөтөлбөрт төслийн нөлөөлөлд өртөх орчин тус бүрийг хянах гол үзүүлэлтүүд, хяналт шинжилгээ хийх давтамж, шинжлэх арга, дээж авах, хадгалах, тээвэрлэх шинжлэхэд баримтлах стандарт шаардлага зэргийг багтаасан болно. Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ энд заагдсан бохирдуулах эх үүсвэрүүдийг хянах Монгол Улсын хууль тогтоомж, стандартчилагдсан арга зүйн хязгааруудыг баримтлах шаардлагатай ба дээрх эрх зүйн актууд, стандартууд шинэчлэгдвэл түүний шинэчилсэн хувилбарыг мөрдөж ажиллах ёстой. Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлж үр дүнг нь доорх асуудлуудыг тодорхойлох, үнэлэхэд ашиглана. Үүнд:

- Анх таамагласан сөрөг нөлөөллүүдийн хэмжээ, үр дагавраас бодит сөрөг нөлөөлөл, түүний үр дагавар хэр зөрж байгааг,
- Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилт болон холбогдох эрх зүйн баримт бичиг, стандарт, дүрэм журамтай нийцэж байгаа эсэхийг,
- Нөлөөллүүдийн эрчим, буурах эсвэл ихсэж байгааг,
- Төслийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний нийт үр ашгийг үнэлэх зэрэг орно.

4.2.1 БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Байршил	Хугацаа ба давтамж	Хяналт шинжилгээний ажлын хэмжээ	Нэгжийн өртөг мян.төг	Нийт зардал, сая.төг	Баримтлах стандарт ба арга, аргачлал
Агаарын чанар								
1	- Хүхэрлэг хий (SO₂) - Азотын ислүүд (NO_x) - PM 2.5 - PM10 - TSP нийт тоос - Нүүрстөрөгчийн дутуу исэл (CO)	мкг/м ³	Ажилчдын түр кемп	Гадаад орчны агаарын чанарын судалгааг бүтээн байгуулалтын үед жилд 1 удаа хийнэ.	110/11 кВ дэд станцын талбайд 1 удаа	Нэг удаа: 65.0 Нийт 1 цэгт * 1 удаа = 65.0	0.065	MNS 4585-2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага, MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга MNS 0017-2-5-11:1988 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга,
Хөрсний төлөв байдал, чанар								
2	- Хөрсний орчин - Ялзмагийн агууламж мг/кг - Карбонатын агууламж - Хөрсний ширхэгийн бүрэлдэхүүн - Хүнд металлын агууламж	мг/кг	Ажилчдын түр кемп	Бүтээн байгуулалтын үед жилд 1 удаа	110/11 кВ дэд станцын талбайд 1 удаа	68.5	0.068	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга, MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга, MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох Мачигины арга MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром,

								кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох. Дөлний болон цахилгаан дулааны атомын шингээлтийн спектрометрийн арга MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга
Усны чанар								
3	- Усны орчин pH - Эрдсийн бүрэлдэхүүн - Хүнд металлын агууламж - Микробиологи	хүн/өдөр	Трассын дагуу байрлах худаг, булаг, шанд, инженерийн хийцтэй худаг	Жилд 1 удаа	Нэг удаагийн шинжилгээнд трассын ойр орчмын худгаас дээж авч шинжлүүлнэ.	71.5	0.075	4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж MNS 13.060.50 Усны чанарын стандарт MNS 0900: 018 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
Ургамлын аймаг								
4	Ургамлын мониторинг судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Хүн/өдөр	Ажилчдын түр кемп	Бүтээн байгуулалтын үед жилд 1 удаа	Нэг удаагийн судалгаанд мониторингийн 5 цэгт ургамлын бичиглэл хийж өөрчлөлтийг үр дүнд тусгана.	500	0.5	Бэлчээрийн газрын хөрсний элэгдэл эвдрэл, ургамлын талхагдлыг тогтоох ерөнхий шаардлага. MNS 5546: 2005 Ургамлын мониторинг хийх гадаад ба дотоодын судлаачдын гаргасан аргачлал, аргазүйг баримтална.
5	Суурилуулсан "шувуу үргээх" төхөөрөмжүүдийн бүрэн бүтэн байдлыг байнга шалгах, үр дүнтэй	Шугам тэмдэглэх төхөөрөмжийн тоо	242 км ЦДАШ-ын дагууд	Жилд 1 удаа	Жил бүр бүх шувуу үргээгчийн бүрэн бүтэн байдлыг хянана.	740	0.74	Байгаль орчин хариуцсан мэргэжилтэн

	байгаа эсэхэд хяналт тавих							
ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН НИЙТ ЗАРДАЛ /САЯ.ТӨГ/				10.53				

4.2.2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУВААРЬ

Төсөл хэрэгжүүлэгч жил бүр Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар БОУАӨЯ-д тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллагад тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хагас жил тутамд хүргүүлнэ. Мөн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар танилцуулгыг хагас жил тутамд хийнэ.

4.2.2.1 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг тайлагнах хуваарь

№	БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Хариуцах эзэн
1	Төрийн захиргааны төв байгууллага /БОУАӨЯ/	Тухайн жилийн БОМТ-ний төсөлтэй хамтатган ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагад хүргүүлнэ.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тухай	Жил бүрийн 1-р улирал дотор	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулах	Төсөл хэрэгжүүлэгч
2	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн бүх шатны Засаг дарга	БОМТ тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж тайланг хүргүүлэх	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тухай	Жил бүрийн 11 дүгээр сарын 01-ний дотор	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнаж олон нийтэд таниулж санал авах	Төсөл хэрэгжүүлэгч